

ТАНИЛЦУУЛГА

2019 оны 3 дугаар улиралд Дэлгэрцогт сумын төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тухай

2019-09-24

Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Багийн Засаг дарга болон мэргэжилтнүүдэд хандан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэхдээ холбогдох албан тушаалтнууд "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол улсын хууль, Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 67-р тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон амаар, бичгээр, 98133483 утсаар, цахимаар болон боломжит бүхий л хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэлтийн явцыг байгууллагын удирдах ажилтнууд, мэргэжилтнүүдийн цуглаанд танилцуулан ажиллаж байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн СӨГ-ыг СӨГ бүртгэх дэвтэрт бүртгэн, холбогдох албан тушаалтанд өгч шийдвэрлүүлж, хариуг эзэнд нь утсаар болон албан тоотгоор өгч байна.

2019 оны 3-р улиралд иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж амаар бичгээр, нийт 18 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснийг 100% хугацаанд нь шийдвэрлэлээ.

Эдгээр санал, өргөдөл, хүсэлтийн дийлэнх нь газар эзэмших, өмчлөх, ашиглах, овог нэр солиулах, иргэний үнэмлэхний сунгалт, иргэний үнэмлэх шинээр авах, халамжид хамрагдах зэрэг асуудлууд байна.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:
ЗДТГ-ЫН ДАРГА С.НАРАНТУНГАЛАГ

